



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№03
/217/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.05

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ ЦЭРЭГ 2022 ОНД...



Тулгар төрт улсынхаа, их Монгол түүхийнхээ түүхээ манлай нь, төгөлдөр эрч хүч нь, уухайн түрлэг нь, урагшлан тэмүүлэх их зориг нь болсон Монгол цэрэг улиран одсон жилдээ Орчин цагийн Зэвсэгт хүчнийхээ нэгэн зууны баялаг намтрыг баринтаглан үндсэн билээ. Мөн Олноо өргөгдсөн шинэ Монголын төрийн хэргийг эрхлэн шийдэх анхны таван яамны нэг болж байгуулагдсан батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу эдүгээгийн Батлан хамгаалах яам маань бүтэн нэгэн зуун аравныхаа

анхны хуудсан дээр түүхээ бичиглэж эхэллээ.

Өнгөрсөнд хийж бүтээсэн үйл хэрэг, хэлхэж бүтээсэн алдаа оноо өрнүүн байгаагийн адил энэ жил хийгээд ирээдүй алсад бодож төлөвлөсөн зорилго зорилт, улс орондоо бүтээн байгуулах асар их ажил үйлс та биднийг хүлээж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичиг "Алсын хараа-2050"-д туссанаар 2020-2030 оны I үе шатыг "Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрийг

хөгжүүлэх үе" гэж тодорхойлсон. Мөн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд батлан хамгаалах чиглэлээр "Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ" гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Үүнтэй уялдуулж цэргийн шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудаас батлан хамгаалахын дэвшилтэт технологийг авч

нутагшуулах, цэргийн шинэ технологид суралцуулахаар гадаад орнуудад цэргийн алба хаагчдыг урт, богино хугацаанд илгээх, Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник, хэрэгслийг зохион бүтээх, үйлдвэрлэх, сайжруулах, технологи нутагшуулах талаар судалгаа, туршилт явуулж, инновацыг тасралтгүй хөгжүүлэх, судалгааны үр дүнд үндэслэн цэргийн зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа тасралтгүй хийгдсээр байна, цаашид ч улам өргөжнө.

Мөн "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн хүрээнд "Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Дайны байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" зэрэг хуулиудыг УИХ-аар хэлэлцүүлнэ. Мөн "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг УИХ-ын намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. Хууль батлагдсанаар хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын алба хаагчид, тэр дундаа эмэгтэй цэргийн алба хаагчидтай холбоотой эрх зүйн байдал, нийгмийн баталгаа улам сайжрах юм.

Ургэлжлэл нь арын нүүрт!

Түүхэнд энэ өдөр

1920 он.

Гамингийн цэргүүд Монгол цэргийн зэвсгийг хураав.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-26

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,846.0	2,851.0
EUR	3,222.0	3,235.0
CNY	431.00	436.10
RUB	36.38	38.43
JPY	24.70	24.80
KRW	2.37	2.39

ЦЭРГИЙНХЭН САЙН ҮЙЛСИЙН АЯНД НЭГДСЭЭР БАЙНА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал нийгмийн хариуцлагын хүрээнд Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хэд хэдэн чиглэлээр хамтран ажиллаж байна. Тухайлбал, тус командлалын нийт бие бүрэлдэхүүн сар бүр цалингийнхаа тодорхой хэсгээр нийгмийн зорилтот бүлгийн багачуудад хандив цуглуулж, бэлэглэж хэвшээд байна. Хандивын аяны хариуд Монголын Улаан загалмайн нийгэмлэгээс "Хүүхэд бидний ирээдүйн төлөө их үйл хэрэг бүтээгч цэргийн ах, эгч нартаа баярлалаа" хэмээх талархлын захидал ирүүлээд байгаа юм.

Мөн Ховд аймгийн Улаан загалмайн хорооны санаачилсан "Santa challenge" хөдөлгөөнд Зэвсэгт хүчний 123 дугаар ангийнхан

нэгджээ. Зорилтот бүлгийн хүүхэд, багачуудад туслах, хүнлэг энэрэнгүй үзэл төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, итгэл үнэмшлийг нь нэмэгдүүлэх зорилготой энэхүү хөдөлгөөнд нэгдсэн тус ангийнхан орон нутгийн багачуудад сэтгэл шингэсэн гарын бэлгээ шинэ жилээр гардуулан өгсөн байна.

Үүний сацуу Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн мөрдөстэй бүсгүйчүүд Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд зорилтот бүлгийн 100 гаруй бяцхан багачуудад бэлэг тараажээ. Тэд ийнхүү сайн үйлс хийхийн зэрэгцээ цэргийн алба хаагчдын гэр бүлийн хүрээнд өдөрлөг зохион байгуулж, цэргийн албыг ойлгон мэдэрч, дэмжиж явахыг эр цэргийн гэргий нарт захисан юм.

ӨГЛӨӨНИЙ ДАСГАЛД УРЬЖ БАЙНА

Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны даргын тушаалаар БХЯ, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд биеийн жингийн зохистой харьцааг хангах зорилгоор "Табата" дасгалыг 7 хоног бүр даваа, лхагва, баасан гаригуудад зохион байгуулж байна. Ажлын цаг эхлэхээс өмнө буюу

өглөө 06.30 цагт эхэлж, 07.50 цагт дуусгах энэхүү дасгалд хамрагдсанаар алба хаагчид үндсэн ажлын цагийн бүтээмжид сөргөөр нөлөөлөхгүйгээр биеийн зохистой харьцаагаа хангаж, эрч хүч хуримтлуулж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зэрэг давуу талтай байна.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,266,225 /69.7%/	2,164,363 /66.5%/	919,478 28,3%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
7258 +112	273	6857

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 295,421,866
Эдгэрсэн
Нийт: 256,046,393
Нас барсан
Нийт: 5,473,007

2022.01.05 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 3/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно Наран ургах, шингэх: 08.41-17.14 Барилдлага: Рашаан Шүтэн барилдлага: Тийн мэдэхүй Суудал: Төмөр

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамцыг сэрээх, гарагийг тахиж, тангараг тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Бага хүйтэн болох улирал (17 цаг 45 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай баялаг төгс болно.

Цахим шууданд

МОНГОЛ ЦЭРЭГ 2022 ОНД...



Түрүүч нь эхний нүүрт!

Аливаа ажлыг бодит болгох, салбарын нийгэмд эзлэх байр суурийг дархлахад төсөв хөрөнгөний асуудал нэн чухал билээ. Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын улсын төсөвт эзлэх хувийг нэмэгдүүлэх замаар салбарын төсвийг Хөгжлийн төсөв болгох нь нэн чухал юм. Энэ нь улс орны эдийн засгийн чадамжаас хамаарах хэдий ч үүнийг бодит ажил хэрэг болгох шаардлага бий. Хэдийгээр батлан хамгаалах төсөв өмнөх онуудаас тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа ч улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ өсөөгүй хэвээр л байна. Харин батлан хамгаалах салбарын 2021 оны төсөв улсын төсвийн зарлагын 2 хувьтай тэнцүү байсан бол төсвийн шинэчлэлтэй холбогдуулан 2022 оны төсөв 2,4 хувь болж өссөн. Тухайлбал, ЗХЖШ-ын төсөв урд оны төсвөөс 18 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан нь өмнөх жилүүдэд хүрэлцэхгүй байсан цалин хөлс, нормт хувцасны хангалт, тогтмол зардлууд болон бусад зардлууд тодорхой хэмжээгээр шийдэгдэх нөхцөл бүрдсэн юм. Мөн манай Цэргийн төв эмнэлгийн үйл ажиллагааны зардал 100 хувь гүйцэтгэлээр буюу Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр тусгагдсан нь онцлох үйл явдал билээ. Бид цэргийн техник хэрэгслээ хийгээд эхэлчихлээ. Дээрээс нь зэвсэг засвар үйлдвэрлэлийн тусгай ангид байлдааны шинэ техникүүд үйлдвэрлэж буйн зэрэгцээ байлдагч нэг бүрийн хувийн зэвсэглэлийг сайжруулах ажлыг өөрсдөө хийж байна. 2022 оны улсын төсөвт "Бага бууны сумны үйлдвэр" байгуулахад шаардагдах хөрөнгийг Батлан хамгаалахын сайдын багцад тусгуулж чадсан бөгөөд Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд сумны үйлдвэрээ барьж, дотооддоо сумаа үйлдвэрлэх ажлыг бодит болгох төдийгүй цаашид экспортлох боломжтой юм.

Монгол Улсын нэр хүнд, Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, чадавхад асар их нөлөө үзүүлж байгаа нэг асуудал бол НҮБ-д цэрэг хандивлагч орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлж, даян дэлхийн амар амгаланг тогтоох энхийн үйлсэд оролцож буй явдал гэж үздэг. Энэ онд Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсоны 20 жилийн ой тохионо. Энэ хүрээнд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсон эмэгтэйчүүдийн олон улсын чуулга уулзалтыг 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ нь Монгол Улсын Зэвсэгт

хүчний алба хаагчдын энхийг дэмжих ажиллагаанд идэвхтэй оролцож байгаагийн илрэл, Монгол цэрэг-Дэлхийн цэрэг болж чадсаны баталгаа болсон нэгэн онцлог тэмдэглэлт үйл явдал юм.

Өнгөрсөн хугацаанд манайхан бүтээн байгуулагч салбар байх зорилтын хүрээнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, "Газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн бүтээн байгуулалт, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам, ургац хураалт, "Тавантолгой түлш" ТӨҮГ-ын түүхий эдийн тээвэрлэлт, "Хөвсгөл нуур"-ын экосистемийн хамгаалалт зэрэгт оролцсон нь улс орны эдийн засгийн болон өнөөгийн хүнд хэцүү цаг үед Зэвсэгт хүчин үүрэг гүйцэтгэхэд бэлэн байгааг илтгэсэн чухал арга хэмжээ болсон. Цаашид ч эдгээр бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, барилга-инженерийн ангиудыг төмөр зам, авто зам, нефтийн үйлдвэр, цахилгаан станцын барилга зэрэг улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд үргэлжлүүлэн оролцуулна. Үүний зэрэгцээ цөлжилттэй тэмцэх, экологийн үйлсэд Зэвсэгт хүчний алба хаагчид идэвх оролцоогоо эрчимжүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнөөр 2030 он гэхэд 22 сая гаруй модыг тарьж ургуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

"Эх орноо хайрлах сэтгэлд их багын хэмжээ гэж үгүй. Түүний төлөө бүхнийг хийгээгүй бол юу ч хийгээгүй гэсэн үг. Буй бүхнээ түүнд зориулаагүй бол бүхнийг харамласан гэсэн үг" хэмээн Людвиг Берне хэлсэн байдаг. Ийм л эх оронч үзэл, хүмүүжлийг Монгол Улсын иргэн бүрд, хүүхэд залуучуудад төлөвшүүлж, амьдралын зөв чиг хандлагатай болгох үүргийг хуулиар хүлээлгэсэн нэг томоохон чиглэлийн хүрээнд Зэвсэгт хүчин хэрэгжүүлдэг. Цэргийн албаар дамжуулж, залуучуудын хандлагыг өөрчлөх, цэргийн мэргэжилд сургах, ар гэрээ аваад явах чадвартай сэтгэлийн хаттай гэрийн эзэн эр хүнийг төлөвшүүлэх зэрэг нийгэмд өөрчлөлт авчрах үйл ажиллагаа юм. Тиймээс манай салбар хугацаат цэргийн албыг учир утгатай болгоё гэсэн зорилт тавин ажиллаж байна. Цэргийн алба хаасан тохиолдолд ажлын байр нь хадгалагддаг байх, сургууль дамжаанд суралцах эрх нь нээлттэй байх, төрийн албанд шууд ордог байх, бизнесийн зээлд эхний ээлжид хамрагддаг байх, орон сууцны хөтөлбөрт нэн тэргүүнд хамруулдаг байх зэрэг асуудлыг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт оруулж

батлуулсан. Энэхүү асуудлыг энэ онд Цэргийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийднэ. Мөн манай салбарт "Хандлагаа өөрчилж, хариуцлагаа дээшлүүлбэ" гэсэн уриалга ажил хэрэг болж, өрнөөд багагүй хугацаа өнгөрч байна. Аливаа зүйлд хандах хандлага нь тухайн хүний мөн чанарыг тодорхойлдог гэдгийг салбарын алба хаагчид, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн гүнзгэр ухамсарлаж ажлаа чин сэтгэлээсээ, санаачилгатай, зөв хандлагаар хийдэг байх нь чухал. Энэ ч үүднээс тухайн албан тушаалынхаа шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан, офицер, ахлагчийн ёс зүйг чанд баримталдаг, сахилгатай, хариуцлагатай алба хаагчдыг дараагийн шатны сургалтад хамруулдаг, албан тушаалд нь томилдог байх бодлогыг салбарын удирдлагууд баримтлан ажиллаж байна.

"Алсын хараа-2050" болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд батлан хамгаалах талаар 12 томоохон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт бүхий ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан байдаг. Тухайлбал, бага бууны сумны үйлдвэр байгуулах, улсын агаарын хилийн хяналтын системийн чадавхыг нэмэгдүүлэх, "Налайх" аэродромын үндсэн зурвасыг сэргээн засварлах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарыг туулах чадвар сайтай тусгай зориулалтын болон цэргийн тээврийн хэрэгслээр хангах, судалгаа туршилтын нэгдсэн лаборатори байгуулах, "Цэргийн жишиг хотхон" төслийг хэрэгжүүлж, анги, байгууллагын бүтээн байгуулалтыг эхлүүлэх зэрэг ихээхэн хөрөнгө, хүч шаардсан төсөл, арга хэмжээ багтаж байгаа юм. Эдгээрийг бодит ажил хэрэг болгон ажиллах нөөц, хүч бололцоо бидэнд хангалттай бий. Гагцхүү шат шатандаа сэтгэл зүтгэл гарган хичээж ажиллах нь чухал юм. Тиймээс 2022 он бидний хувьд "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах талаар туссан томоохон зорилт, арга хэмжээнүүд бодит ажил хэрэг болсон, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт улам эрчимжсэн, их бүтээн байгуулалт өрнөсөн, Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдсэн, зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэлт, алба хаагчдын маань нийгмийн хамгааллын асуудалд тодорхой ахиц гарсан сайхан жил болно" хэмээсэн Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын итгэл төгс өгүүлснээр энэхүү нийтлэлээ өндөрлөө.

Д.ГҮНЖИЛМАА

БАР ЖИЛИЙН САР ШИНИЙН БАЯРЫГ УГТАН ЗОХИОН БАЙГУУЛАХ "ЦАГААН САР-МОНГОЛ ТҮМНИЙ УЛАМЖЛАЛТ ИХ БАЯР" ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

ЗОРИЛГО: Монгол түмний үндэсний өв соёл, дуу хуур, тоглоом наадгай, түүх шаштир, утга зохиол, бичиг соёлын өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, Зэвсэгт хүчний анги байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, үндэсний соёл урлагийг нийтэд сурталчлан таниулах, Монголын үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой нийцүүлэн хөгжүүлэхэд оршино.

Нэг. Тэмцээнийг зохион байгуулах хугацаа, хамрах хүрээ

Энэхүү тэмцээнд Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчдаас бүрдсэн 5 хүнтэй 1 баг, ангийн удирдлагаас 1, нийт 6 хүн хамт олноо төлөөлөн оролцоно.

Тэмцээнийг 2022 оны 01 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд 11:00 цагаас Офицеруудын ордонд 2 үе шаттайгаар зохион байгуулна.

1 дүгээр шатны шалгаруулалтад бүх багууд сугалаа сугалж, тэмцээнд оролцох өдөр болон гарааны дарааллаа тогтооно.

2 дугаар шатны шалгаруулалтад шилдэг 8 баг дахин сугалааны дарааллаар өрсөлдөнө.

Багийн мэдүүлгийг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн 14-ний өдрийн 12:00 цаг хүртэл ЦДБЭЧ-ын 205 тоот өрөөнд хүлээн авч, оролцогч тус бүрд Мандат олгоно. /Мандатын үнэ 20.000 төгрөг/



Тэмцээний техникийн зөвлөгөөн 01 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 цагт ЦДБЭЧ-ын "Соёмбо" танхимд болно.

Багийн дэлгэрэнгүй мэдүүлэгт ангийн танилцуулга, оролцох багийн нэр, оролцогчдын цол, нэр, албан тушаал, нас хүйс, төрсөн газар, хобби, гавьяа шагнал зэрэг багтсан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг : 99711435, 89074727

Хоёр. Тэмцээнийг зохион байгуулах журам

Тэмцээнийг ЗХЖШ, ЦДБЭЧ, мэргэжлийн уран бүтээлчид, соёл урлагийн судлаачдаас бүрдсэн шүүгчдийн бүрэлдэхүүн шүүн явуулна.

Тэмцээнд оролцох багийн гишүүд бүгд вакцины 3 дугаар тунд хамрагдсан байх, тэмцээн эхлэх өдөр түргэвчилсэн шинжилгээ өгсөн байх шаардлагатай.

Тэмцээний үеэр хэвлэл мэдээллийн байгууллагуудын сэтгүүлч, сурвалжлагчид мэдээ мэдээлэл бэлтгэж, нийтэд мэдээлэн сурталчлах ажлыг зохион байгуулах бөгөөд телевизийн бичлэг хийж, Сар шинийн баяраар олон нийтэд хүргэнэ.

Шүүгчид багуудын оролцсон тэмцээн, үзүүлбэр тус бүрд 1-10 оноо өгч, онооны нийлбэр дүнгээр байр эзлүүлнэ.

Гурав. Тэмцээний болзол

1. "МЭНДЧИЛГЭЭ"- Багууд сар шинийн баяр болон ардын уламжлалт ёс заншлыг харуулсан, өөрийн анги байгууллага, багийн бэлгэдлийг илэрхийлсэн, 8-10 минутын мэндчилгээ бэлтгэж оролцоно. Мэндчилгээг урлагийн бүхий л төрөл хэлбэрээр илэрхийлж болох бөгөөд багийн бүх гишүүн заавал оролцсон байна. Анги хамт олноос 5 хүртэлх хүний оролцоогоор дэмжлэг авч болно.
2. "ШАГАЙ ШҮҮРЭХ"- Тухайн багаас 1 оролцогч багаа төлөөлөн бусад багийн оролцогчидтой Монголын үндэсний уламжлалт тоглоом болох "Шагай шүүрэх" наадгайгаар 3 тойрог наадаж өрсөлдөнө.
3. "ЗААВАЛ ДУУЛАХ ДУУНЫ ТЭМЦЭЭН"- Тэмцээнд тухайн ангийн удирдлагыг төлөөлөн ангийн ТЭРГҮҮН АХЛАГЧ /Бригад, хороо, батальоны/ нар өрсөлдөж, Монгол ардын "Янлинхуар" дууг дуулж өрсөлдөн, тэмцээнд оролцож буй багтаа оноо авчирна.
4. "АРДЫН ДУУНЫ ХҮҮХНҮҮД" ТЭМЦЭЭН - Уг тэмцээнд багийн гишүүдээс 1 хүн оролцож, дараах дуунуудаас сугалааны оноолтын дагуу дуулж өрсөлдөнө. /ЦДБЭЧ-ын Үндэсний найрал хөгжимчдөөс мэргэжлийн дэмжлэг авах боломжтой. /Нэг дууг 3-4 бадаг дуулна./

Дуулах дуунууд :

- "Хандармаа"
- "Дүүриймаа"
- "Сүнжидмаа"
- "Бүүжидмаа"
- "Гавалмаа"
- "Хоожиймаа"
- "Хүүхэн нанаа"
- "Гэвээ бүсгүй"
- "Цэвэр охин"
- "Сэндэр охин"

5. АСУУЛТ ХАРИУЛТЫН ТЭМЦЭЭН – Багийн гишүүд 1 минутын хугацаанд бодож, "Төрийн шагнал хүртсэн зохиолууд-I,II,III" номоос өгөгдөх асуултын тэмцээнд багаараа оролцож өрсөлдөнө.

Дөрөв. Байр эзлүүлэх журам

Багуудыг онооны нийлбэрээр байр эзлүүлнэ. Оноо тэнцсэн тохиолдолд шүүгчид багийн ахлагч нарын дунд дахин 1 тэмцээн явуулж шийдвэрлэнэ.



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
 Батлан хамгаалах яам
 Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
 "Соёмбо" сонин
 "Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
 * Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
 * Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
 Индекс: 10018
 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
 Утас: 70001029, 3412 (дотуур)